**ДОРНОГОВЬ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 30 өдөр Дугаар А/73 Сайншанд сум

Биеийн тамир, спортын газрын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.9 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 276, 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллага Биеийн тамир, спортын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсугай.

2.Аймгийн Биеийн тамир, спортын газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

3.Сумдын биеийн тамир, спортын албан хаагчид, үйлчилгээний ажилтнуудын 2023 оны цалингийн зардал 304,490,600 (Гурван зуун дөрвөн мянга дөрвөн зуун ерэн мянга зургаан зуу) төгрөгийг сар, улирлын хуваарийн дагуу орон нутгийн төсвөөс гарган санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Содхүү)-т зөвшөөрсүгэй.

4.Ажилтан, албан хаагчдын ажлын чиг үүргийг нарийвчлан тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс гэрээ байгуулан, удирдлага, арга зүйгээр хангаж, нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааг эрчимжүүлж, сумдад биеийн тамир, спортыг хөгжүүлэн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга (Г.Батлхам)-д үүрэг болгосугай.

5.Сумын биеийн тамир, спортын албан хаагчид, үйлчилгээний ажилтнуудыг өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагаанд хяналт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
44 1 23002 12
20__ он __ сар __ өдөр

тавьж, нийтийн биеийн тамир, спортыг өргөжүүлэн ажиллахыг зарим сумдын Засаг дарга, Соёл, спортын төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Хонгорзул)-т даалгасугай.

7.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/ 945, А/947 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
Гарын үсэг:
20.... он ... сар ... өдөр

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/73 дугаар захирамжийн хавсралт

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО, АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

| № | Албан тушаалын нэрс | Орон тоо | Ангилал, зэрэглэл |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Биеийн тамир, спортын газрын дарга | 1 | ТЗ-4 |
| 2 | Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтэн | 1 | ТЗ-8 |
| 3 | Нягтлан бодогч | 1 | ТҮ-8 |
| 4 | Хүний нөөц, дотоод хяналт хариуцсан ажилтан | 1 | ТҮ-7 |
| 5 | Маркетинг, нийтлэг үйлчилгээ хариуцсан ажилтан | 1 | ТҮ-7 |
| 6 | Нийтийн биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 7 | Сагсан бөмбөгийн дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 8 | Жүдо бөхийн дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 9 | Волейболын дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 10 | Хөл бөмбөгийн дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 11 | Боксын дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 12 | Чөлөөт бөхийн дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 13 | Усан спортын дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 14 | Усан спортын аврагч | 1 | ТҮ-6 |
| 15 | Эмч | 1 | ТҮ-6 |
| 16 | Зохион байгуулагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан | 1 | ТҮ-5 |
| 17 | Зохион байгуулагч /Усан спорт сургалтын төв/ | 1 | ТҮ-5 |
| 18 | Бичиг хэрэг, архивын ажилтан | 1 | ТҮ-5 |
| 19 | Нярав | 1 | ТҮ-4 |
| 20 | Цахилгаанчин | 1 | ТҮ-3 |
| 21 | Сантехникч | 2 | ТҮ-3 |
| 22 | Үйлчлэгч | 6 | ТҮ-1 |
| 23 | Жижүүр | 9 | ТҮ-1 |
| 24 | Сахиул | 1 | Гэрээт |
| САЙНШАНД СУМЫН 5 ДУГААР /ЗҮҮНБАЯН/ БАГ | | | |

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
Гарын үсэг:
20 . . . он . . . сар . . . өдөр

| | | | |
|---|---|---|---|
| 25 | Дасгалжуулагч | 2 | ТҮ-6 |
| 26 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 27 | Жижүүр | 3 | ТҮ-1 |
| 28 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | ХӨВСГӨЛ СУМ | | |
| 29 | Дасгалжуулагч | 2 | ТҮ-6 |
| 30 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 31 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | УЛААНБАДРАХ СУМ | | |
| 32 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 33 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | ХАТАНБУЛАГ СУМ | | |
| 33 | Дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 34 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 35 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | АЙРАГ СУМ | | |
| 36 | Дасгалжуулагч | 2 | ТҮ-6 |
| 37 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 38 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | ДЭЛГЭРЭХ СУМ | | |
| 39 | Дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 40 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | ИХХЭТ СУМ | | |
| 41 | Дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 42 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 43 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | ЗАМЫН-ҮҮД СУМ | | |
| 44 | Дасгалжуулагч | 1 | ТҮ-6 |
| 45 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 46 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | ӨРГӨН СУМ | | |
| 47 | Дасгалжуулагч | 2 | ТҮ-6 |
| 48 | Биеийн тамирын арга зүйч | 1 | ТҮ-6 |
| 49 | Үйлчлэгч | 1 | ТҮ-1 |
| | **Нийт** | 70 | |